ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 12 өдөр Дугаар 539 Улаанбаатар хот

"Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компани
нэмэлт хувьцаа гарган, хөрөнгийн биржээр олон нийтэд
нээлттэй арилжих тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 56 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн 231,305,936 (хоёр зуун гучин нэгэн сая гурван зуун таван мянга, есөн зуун гучин зургаан) ширхэг энгийн хувьцаа дээр 119,157,603 (нэг зуун арван есөн сая, нэг зуун тавин долоон мянга зургаан зуун гурван) ширхэг энгийн хувьцааг нэмж гаргаж, хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгосугай.

2. Олон нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг 100 (нэг зуун) төгрөгөөр тогтоосугай.

3. "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжих үйл ажиллагааг Үнэт цаасны тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулахыг "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (С.Тулга), Гүйцэтгэх захирал (Х.Алтай) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжих үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус компанийн Хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчид зөвлөсүгэй.

5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Ц.БАЯР-ЭРДЭНЭ

29-r huraldaan